



**Монгол Улс: Ухаалаг засаг-2 төсөл**

**Байгаль орчны асуудлаар баримтлах журам**  
**(Барилгын туслах ажил, тоног төхөөрөмжийн суурилуулалт)**

**Цахим хөгжил, харилцаа холбооны яам**

Төсөл хэрэгжүүлэх нэгж

**2024 он**

## Агуулга

1	Ерөнхий мэдээлэл	3
1.1	Төслийн мэдээлэл	3
1.2	БОАБЖ-ын зорилго	4
1.3	Холбогдох хууль, тогтоомж ба Дэлхийн Банкны дүрэм, журам	4
2	БОАБЖ-д тавигдах шаардлага	6
2.1	Зураг төсөл дэх эрсдэл бууруулах арга хэмжээ ба тендэрийн баримт бичиг боловсруулах	6
2.2	Барилга, угсралтын ажил туслан гүйцэтгэгчийн байгаль орчны асуудлаар баримтлах дүрэм	6
2.3	Олон нийтэд мэдээлэл хүргэх, хүртээмжтэй байх	7
2.4	Хориглох зүйлс	7
2.5	Тээвэрлэлт	8
2.6	Ажиллах хүч	8
2.7	Хог хаягдлын менежмент ба хөрсний элэгдэл:	8
2.8	Газар шорооны ажил, хотгор, гүдгэр газрыг тэгшлэх	11
2.9	Барилгын ба тээврийн хэрэгслээс гарах хаягдал	11
2.10	Барилгын ажлын үед баримтлах аюулгүй байдал	11
2.11	Дуу чимээ, таагүй байдал болон тоосны хяналт	12
2.12	Одоо байгаа дэд бүтцийн байгууламжуудыг буулгах	13
2.13	Олон нийттэй харилцах	13
2.14	Соёлын биет өвийн санамсаргүй олдох журам	14
2.15	Ажилтан, ажиллагсадын эрүүл мэнд ба КОВИД-19	14
2.15.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)-н арга хэмжээ	14
2.15.2	COVID 19-ээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	15
2.16	Байгаль орчны боловсрол олгох сургалт	15
	Хавсралт 1: Барилгын талбайн байгаль орчныг хамгаалах хяналтын шалгах хуудас	17

# 1 Ерөнхий мэдээлэл

## 1.1 Төслийн мэдээлэл

“Ухаалаг Засаг-2” төсөл нь иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүргэх төрийн цахим үйлчилгээний аюулгүй байдал, чанар, үр өгөөжийг дээшлүүлэх мөн дижитал үр чадвар, дижитал технологи бүхий ажлын байрыг нэмэгдүүлэх зорилготой. Тус төсөл нь таван бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 1 нь дижитал шилжилт, холболтын талаарх бодлого, зохицуулалтыг бэхжүүлэх замаар дижитал шилжилтийг идэвхжүүлэх орчныг бүрдүүлэх, төрийн албаны оролцогч талуудын менежментийг өөрчлөх, мөн иргэдийн цахим оролцоог дэмжихэд тусална.

Бүрэлдэхүүн хэсэг 2 нь e-Mongolia порталын дижитал төрийн үйлчилгээг нэмэгдүүлэх, сайжруулах, Монгол Улсын Засгийн газрын Үндэсний дата төв (ҮДТ) болон Гамшгаас хамгаалах улсын алба (ГХУА)-ыг шинэчлэх, Кибер аюулгүй байдлын шуурхай ажиллагааны багийг бүрдүүлэх замаар цахим засаглалын шилжилтэд чиглэнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 3 нь дижитал эдийн засгийг хөгжүүлэх, төр болон иргэдэд дижитал үр чадвар олгох сургалтыг дэмжих, залуучууд, ялангуяа эмэгтэйчүүдэд дижитал үр чадвар, ажлын байр бий болгох, ЖДҮ-ийн дижитал шийдлүүдийг нэвтрүүлэх зэрэг болно.

Бүрэлдэхүүн хэсэг 4 нь анхны төслөөр байгуулагдсан одоогийн ТХН-ийн ажиллагааг үргэлжлүүлэн, өргөтгөхөд дэмжлэг үзүүлнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 5 нь төрийн албан хаагчдад зайнаас ажиллах нэмэлт систем, бусад дэмжлэг үзүүлэх, мөн алслагдсан эрүүл мэндийн болон боловсролын байгууллагуудын интернет хурдыг сайжруулах зэргээр COVID-19 цар тахлын үед МХХТ-ийн технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх замаар шийдвэрлэх боломжтой аливаа онцгой байдлын хямралд шуурхай хариу арга хэмжээ авах боломжийг бий болгох үүднээс Болзошгүй онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах бүрэлдэхүүн хэсгийг санхүүжүүлнэ.

Биет хөрөнгө оруулалт нь МХХТ-ийн шинэ тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авах, суурилуулах, тогтвортой хөргөх технологийг ашиглахтай холбоотой барилгын жижиг ажлуудаар хязгаарлагдах бөгөөд суваг шуудуу ухах, баригдсан барилгуудыг нөхөн сэргээх, цахилгааны шинэчлэлт хийх, кабелийн шугам татах зэргээр одоогийн ҮДТ (барилгын нийт талбай 1307 м.кв) болон ГХУА-ын (барилгын нийт талбай 310 м.кв) эрчим хүчний болон хөргөх системүүдийн эрчим хүчний ашигтай ажиллагааг нэмэгдүүлэхэд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэгтгэх ажил мөн үүнд багтах юм. МХХТ-ийн дэд бүтцэд олгох санхүүжилт нь шинэ үйл ажиллагаа, үйлчилгээнд зарцуулагдах ба харин одоо хэрэглэж буй програм/үйлчилгээнд ашиглагдаж буй хуучирсан/элэгдсэн мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг солиход зориулагдаагүй бөгөөд ингэхдээ хамгийн сүүлийн үеийн, эрчим хүчний хэмнэлтэт хувилбарыг ашиглана.

Энэхүү Байгаль орчны асуудлаар баримтлах журам (БОАБЖ) нь ДБ-ны Байгаль орчны үнэлгээний шаардлагад нийцүүлэх үүднээс дижитал дэд бүтцийг суурилуулах, байгаль орчны хязгаарлагдмал нөлөөллийг бууруулах боломжтой барилгын жижиг ажилд зориулагдсан. Мөн тус БОАБЖ нь ДБ-ны Байгаль орчин, Эрүүл мэнд, Аюулгүй байдал (БОЭМАБ)-ын зөвлөмжүүд болон Байгаль орчин Нийгмийн хамгаалал(БОНХ)-д үндэслэн бэлтгэгдсэн болно. Энэхүү БОАБЖ

нь ДБ-ны санхүүжилттэй “Ухаалаг Засаг-2” төслийн хүрээнд дижитал дэд бүтэц болон барилгын жижиг ажилд шаардагдах магадлалтай нийт суурилуулалтад хэрэглэгдэх боломжтой юм. БОАБЖ нь МХХТ-ийн тоног төхөөрөмжийг суурилуулалтын явцад үүссэн цахим хог хаягдал зэрэг холбогдох боломжит хязгаарлагдмал Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг шийдвэрлэх болзошгүй онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааг мөн хамарна.

## **1.2 БОАБЖ-ын зорилго**

Шинэ дижитал дэд бүтэц суурилуулах, шаардлага үүсэх магадлалтай барилгын жижиг ажлуудын улмаас байгаль орчны болзошгүй сөрөг нөлөөтэй холбоотой зохих арга хэмжээнүүдийг нарийвчлал, техникийн үндэслэл, санхүүгийн хувьд тогтвортой, ажиллах боломжтой байдлаар танилцуулах, төслийн тендер шалгаруулалт, зураг төсөл, барилгын үе шатуудад ТХН, гэрээ гүйцэтгэгчид, хяналтын инженерүүд, аливаа гуравдагч талын зөвлөхүүдийн хэрэгжүүлсэн байгаль орчны бохирдлыг бууруулах, байгаль орчны менежментийн арга хэмжээнүүдийг тодорхойлох, мөн төслийн бүтээн байгуулалтын явцад үүсэх байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулах зорилгоор энэхүү Байгаль хамгааллын дүрмийг (БХД) боловсруулсан болно.

БОАБЖ-ыг хэрэгжүүлэгчийн үүрэг хариуцлага

Төсөл хэрэгжүүлэх нэгж (Цахим хөгжил, харилцаа холбооны яам)

- БОАБЖ-ын хэрэгжилтийг хангах ерөнхий хариуцлагатай байх;
- Барилга угсралтын ажил, дижитал тоног төхөөрөмж суурилуулах ажлын тендерийн баримт бичиг, барилгын ажил гүйцэтгэгчийн гэрээнд байгаль орчин, нийгмийн шаардлагуудыг тусгах;
- БОАБЖ-ийг хэрэгжүүлэх, хяналт тавихад хангалттай төсвийг хуваарилах; ҮДТ болон Нөөц Төв гэх мэт холбогдох мэдээлэл технологийн байгууламжийн операторуудад зохицуулалт, хяналтын дэмжлэг үзүүлэх;
- Барилгын талбайн байгаль орчны хяналт шалгалтын хуудсыг ашиглаж хяналт тавихад ҮДТ болон НТ гэх мэт мэдээлэл технологийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах

Төслийн үр шим хүртэх ҮДТ болон НТ гэх мэт дижитал дэд бүтцийн операторууд

- Зураг төсөл, инженер, гүйцэтгэгчид нь БОАБЖ-д тусгасан шаардлагуудыг хэрэгжүүлэхийг баталгаажуулах;
- Цахилгаан хэрэгслийн хог хаягдыг БОАБЖ-ын шаардлага болон МУ-ын хууль дүрмийн дагуу боловсруулж, устгах;

Гүйцэтгэгчийн хүлээх үүрэг

Төслийн гүйцэтгэгчид нь БОАБЖ болон байгаль орчин, нийгмийн холбогдох бүх шаардлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Гүйцэтгэгч нь аливаа зөрчлийн талаар ТХН-д мэдээллэж, зохих хариу арга хэмжээг авч байх шаардлагатай.

## **1.3 Холбогдох хууль, тогтоомж ба Дэлхийн Банкны дүрэм, журам**

Төслийн бүх ажил дараах шаардлагыг хангасан байх шаардлагатай.

1. Монгол улсын байгаль орчны хууль тогтоомж, дүрэм журам, стандартууд.
2. ЭХД-1-12-04-2013 Монгол улсын цахилгаан байгууламжийн угсралтын ашиглалтын аюулгүй ажиллагааны дүрэм.
3. Монгол улсын барилгын хууль
4. Галын аюулгүй байдлын тухай хууль
5. Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль
6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт MNS 4994-2000
7. Барилгын материалын хэсэгчилсэн болон бөөний тээвэрлэлт. Ангилал, тээвэрлэлтийн нөхцөл. Ерөнхий шаардлага. MNS 5646:2006
8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Цахилгааны болон галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. MNS 5390:2004.
9. Ахуйн хог хаягдлын тээвэрлэлтийн ерөнхий шаардлага. MNS 5344:2011.
10. Хувийн хамгаалалтын тоног төхөөрөмж. Төрөл зүйл болон ерөнхий шаардлага. MNS 4931:2000.
11. Байгаль орчин. Сүйтсэн газрыг дахин ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5918:2008.
12. Газар хөрсний ажлын явцад үржил шимт хөрсийг хуулж, түр хадгалахад тавигдах байгаль орчны шаардлага. MNS 5916:2008.

Монгол Улсын Засгийн газрын Үндэсний дата төв (ҮДТ) болон Гамшгаас хамгаалах улсын алба (ГХУА)-ыг шинэчлэх явцад төслөөс ашиг хүртэгч барилга өмчлөгчид (Үндэсний дата төв, Гамшгаас хамгаалах улсын алба) орон нутгийн удирдлагуудаас дараах зөвшөөрлийг авна. Үүнд:

1. Онцгой байдлын ерөнхий газраас галын болон аюулгүй байдлын зөвшөөрлүүд
2. Дотоодын, зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагатай хог хаягдал зайлуулах гэрээ хийх. Бүх дүүрэг, сумдад зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж бүх төрлийн хог хаягдлыг зайлуулах устгах ажлыг туслан гүйцэтгэгчийн гэрээний дагуу хийдэг. Хог хаягдлыг хаях цэгийг гэрээнд заасан байна.
3. Шаардлагатай тохиолдолд бусад зөвшөөрлүүд, тухайлбал сэргээгдэх эрчим хүчний төрөл бүрийн суурилуулалт, хаягдал дулааны ашиглалтанд зураг төсөл, техникийн үзүүлэлтүүд дагуу холбогдох зөвшөөрөл.

Эдгээрээс гадна Дэлхийн Банкны доорх Байгаль орчин, эрүүл мэндийн стандартын зааварчилгааг уг төсөлд мөрдлөгө болгоно. Үүнд:

- Дэлхийн Банкны БОЭМС-ын ерөнхий зааварчилгаа
- Дэлхийн Банкны БОЭМС-ын үүрэн холбооны зааварчилгаа
- Дэлхийн Банкны БОНБББ/Аюулгүй байдлын явцын ноот бичиг
- ДЭМБ-ын Ковид-19-ийн асуудлаарх эрүүл мэндийн зааварчилгаа
- Ковидын үеийн ХХХ-ийн ашиглалт ба нөөцийн эрс хомсдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ
- Ковид-19-ийн үеийн маск ашиглалтын зөвлөгөө
- Ковид-19-ийн үеийн ус, ариун цэвэр болон хог хаягдлын менежмент
- Сайн түршлагын тэмдэглэл: Асбест: Хөдөлмөрийн болон нийгмийн эрүүл мэндийн асуудал

## **2 БОАБЖ-д тавигдах шаардлага**

Гүйцэтгэгч, түүний ажилчид болон аливаа гуравдагч талын зөвлөхүүд ТХН-ийн зохицуулалт, хяналт удирдлага дор орон нутгийн иргэдэд хохирол, хүндрэл учруулахаас урьдчилан сэргийлэх, барилга угсралт, ашиглалтын явцад байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах зорилгоор эдгээр техникийн нөхцөлд заасан нөлөөллийг бууруулах арга хэмжээг дагаж мөрдөнө.

### **2.1 Зураг төсөл ба тендерийн баримт бичиг боловсруулах үед эрсдэл бууруулах арга хэмжээ**

Төсөл хэрэгжилтийн үе шатад худалдан авах ажиллагааг Дэлхийн Банкны Худалдан авах ажиллагааны зааварчилгааны дагуу хийж гүйцэтгэнэ. ЦХХХЯ/ТХН нь байгаль орчны аливаа томоохон сөрөг нөлөө гарахаас сэргийлэн, эрсдлийг бууруулах арга хэмжээ болон энэхүү БОАБЖ-г тендерийн баримт бичиг, техникийн үзүүлэлтүүд, ерөнхий зураг, барилгын зураг төсөлд оруулах ажлыг хариуцна. Тендерийн материал нь тендерт оролцогч байгууллагуудаас байгаль орчны менежментийн дараах үүргийг хүлээн, туслан гүйцэтгэх гэрээндээ мөн эдгээрийг тусгасан байхыг шаардана. Үүнд:

1. Барилгын ажил туслан гүйцэтгэгч нь барилгын ажлын талбай бүрт нэг байгаль орчны инженер ажиллуулж, барилгын ажил дуусах хүртэл байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэн, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн гэрээт туслан гүйцэтгэгч нараар БОАБЖ-ын шаардлагуудыг хангуулах ажлыг зохион байгуулна;
2. Барилгын ажлын явцад туслан гүйцэтгэгч орон нутгийн ард иргэдтэй харилцан тохиролцох, барилгын талбай бүрт барилгын ажлын тухай нарийн мэдээлэл, барилгын ажил хэзээ эхлээд хэзээ дуусах, гомдол санал мэдүүлэх, зөвлөгөө авах тохиолдолд холбоо барих хүний нэр, холбогдох дугаар зэргийг харуулсан зарлах самбарыг байршуулна;
3. Туслан гүйцэтгэгч нь барилга эзэмшигчийн томилсон ахлах зааварлагчид байгаль орчны зааварчилгааны ажлуудыг зохион байгуулахад нь идэвхтэй туслалцаа үзүүлж ажиллана.
4. Туслан гүйцэтгэгч нь гэрээнд гарын үсэг зурсныхаа дараа буюу барилгын ажил эхлэхийн өмнө “Барилгын талбайн байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г барилгын хөтөлбөртөө оруулна.
5. Туслан гүйцэтгэгч нь тухайн улсад мөрдөгдөж буй барилгын аюулгүй ажиллагаа, амар амгалан байдлын шаардлагуудад хүндэтгэлтэй хандана.
6. Барилгын ажил туслан гүйцэтгэгч нь энэ БОАБЖ-д дурдсан багйаль орчныг хамгаалах арга хэмжээг дагаж мөрдөөгүйн улмаас үүсэх аливаа хохирлыг барагдуулах үүрэг хүлээх ба энэ тухайгаа Дэлхийн Банкны ТХН-д 24 цагийн дотор мэдэгдэнэ. Хохирлыг барагдуулах арга хэмжээг зохион байгуулахад ТХН туслах үүрэгтэй. Туслан гүйцэтгэгч нь тухайн арга хэмжээг авснаа бүртгэн авч, энэ тухайгаа барилгын ажлын зааварчлах нэгж, ТХН-д мэдээлнэ.

### **2.2 Барилга, угсралтын ажил туслан гүйцэтгэгчийн байгаль орчны асуудлаар баримтлах дүрэм**

Аливаа гэр сууц, албан өрөөний зориулалттай байгууламж, ариун цэврийн өрөө зэрэг нь барилгын талбайд байрлана. Туслан гүйцэтгэгч нь талбайн план зураг гаргаж ТХН/барилгын

эзэмшигч нараас ажил эхлэхийн өмнө зөвшөөрөл авсан байна. План зурагт материал өрж хадгалах газар, хог хаях цэгийг оруулсан байна.

Туслан гүйцэтгэгч нь орчноо байнга цэвэр байлгана. Цэвэр байлгана гэдэгт дараах болон бусад асуудал хамаарна. Үүнд:

- Ажилтнуудынхаа биеэ авч явах байдалд анхаарах;
- Ил гал гаргахгүй байх;
- Тоос дэгдэлтийг хянах, замыг чөлөөтэй байлгах гэх мэт шаардлагатай заалтуудыг биелүүлэх;
- Хогоо ойр ойрхон давтамжтайгаар гаргаж хаях, барилгын ажлын талбайг эмх цэгцтэй байлгах;
- Хүнсний хаягдлыг зайлуулах;
- Барилгын талбарыг зааглах хамгаалалтын байгууламжийг байн байн шалгаж, засаж, шинээр будаж янзлах;
- Дээш өргөгдсөн тавцан/баганыг аль болох хурдан хураах, мэдэгдэл хүргүүлснээс 24 цагийн дотор гэх мэт;
- Ажилчдад зориулсан ариун цэврийн ба амрах байгууламж байлгах;

Ажлын үндсэн цаг 08:00 - 18:00 байх ба амралтын өдрүүдээр 08:00 - 13:00 байна. Эдгээр цагаас гадуурх цагуудад ТХН юмуу эсвэл барилгын эзэд, холбогдох байгууллагаас зөвшөөрөл авахгүйгээр дуу чимээ ихтэй ажил хийж болохгүй. Дээрхээс өөр шаардлага тавих бол талбар тухай бүрт тохируулан зохицуулна.

Барилгын ажил дуусахад туслан гүйцэтгэгч талбайд үлдсэн хог, түр ажлын байгууламжууд гэх мэт төрөл бүрийн зүйлсийг цэвэрлэж, зайлуулна. Ажлын талбай ТХН, хүлээн авагч байгууллага албан тушаалтны сэтгэл ханамжийг хангахуйц байдалд үлдсэн байх ёстой.

### **2.3 Олон нийтэд мэдээлэл хүргэх, хүртээмжтэй байх**

Барилгын талбай руу зөвшөөрөлгүй орж, гарах асуудлыг аль болох хязгаарлана. Хүсэлт тавьсны дагуу барилгын ажлын хуваарь (эхлэх ба дуусах хугацаа), нэмэлтээр утасны дугаарыг нийтийн болон хувийн харилцаагаар мэдээлж болно.

### **2.4 Хориглох зүйлс**

Барилгын талбай дээр болон ойр орчимд дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:

- Барилгын зөвшөөрөгдсөн талбайн гадна байрлах мод тайрах;
- Ан хийх, загасчлах, зэрлэг амьтныг барих, өвс ургамал түүх;
- Хориглосон хорт бодис, материал ашиглах, тухайлбал хар тугалгын орцтой будаг, асбест гэх мэт;
- Архитектур ба түүхэн ач холбогдолтой үнэт зүйлийг үймүүлэх;
- Хог шатаах;
- Мэдээллийн технологийн төхөөрөмж, материал, үлдэгдлийг хууль бусаар хаях;
- Галт зэвсэг ашиглах (зөвшөөрөл бүхий хамгаалалтын ажилтанд хамаарахгүй);
- Ажилчид согтууруулах ундаа хэрэглэх.

- Элс, хайрга, дайрга гэх мэт барилгад ашиглагдах материалыг хууль бус нөөцөөс худалдан авах, хангах.

## **2.5 Тээвэрлэлт**

Гүйцэтгэгч нь төслийн инженертэй тохиролцсоны дагуу төслийн талбайд хүрэх сонгосон маршрут болон тухайн бүс дэх авто замын ангилалд тохирсон овор хэмжээтэй тээврийн хэрэгслийг ашиглах бөгөөд тээврийн зориулалтаар ашиглагддаг орон нутгийн зам, гүүрийг гэмтээхээс сэргийлж ачааллыг тохируулан хязгаарлана. Ачаалал хэтрүүлэн тээвэрлэсний улмаас орон нутгийн зам, гүүрэнд учирсан эвдрэлийг гүйцэтгэгч тал хариуцах төдийгүй төслийн инженерийн зөвшөөрлийн дагуу дээрх эвдрэл сүйдлийг арилгах шаардлагатай.

Гүйцэтгэгч нь дуу чимээ ихтэй ямар ч тээврийн хэрэгслийг засмал болон шороон зам дээр ашиглахыг хориглоно. Аливаа барилгын хэсэгт, гүйцэтгэгчийн хяналт дор бүх моторжуулсан тоног төхөөрөмжид дуу чимээ намсгагчийг шаардлага хангасан нөхцөлд суурилуулж, засвар үйлчилгээ хийнэ.

Гүйцэтгэгч замын хөдөлгөөний зохицуулалтын зохих арга хэмжээг гэрээний нийт хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд уг арга хэмжээг төслийн инженерийн урьдчилан зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлнэ.

## **2.6 Ажиллах хүч**

Туслан гүйцэтгэгч нь ажилчдынхаа дийлэнхийг дотоодын ажиллах хүчнээс бүрдүүлж, шаардлагатай сургалтаар хангана.

Туслан гүйцэтгэгч нь барилгын талбайд болон ойр орчимд хоол хийх, халаах зорилгоор мод түлэхийг зөвшөөрөхгүй.

Туслан гүйцэтгэгч нь талбай дахь албан оффис, депо, цехүүдийг зөв газарт нь байрлуулахад анхаарч ажиллана. Боловсон бөгөөд сайтар цэвэрлэсэн жорлонтой байна.

Туслан гүйцэтгэгч нь ажилчдыг шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслээр нь бүрэн хангана.

## **2.7 Хог хаягдлын менежмент ба хөрсний элэгдэл:**

Бүх хог хаягдлыг гэрээт аж ахуйн нэгж зайлуулах юм уу устгана. Хог зайлуулах гэрээг тухайн улсын зөвшөөрөл бүхий байгууллагатай байгуулж, Байгаль орчны менежментийн хэрэгжилтийн тайланд тус гэрээг хавсарган, ТХН-д тайлагнана. Бүх дүүрэг, сумдад зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж бүх төрлийн хог хаягдлыг зайлуулах устгах ажлыг туслах гүйцэтгэх гэрээний дагуу хийдэг. Хог хаягдлыг хаях цэгийг гэрээнд заасан байна.

Хатуу хог хаягдал, бохирын татуурганаас гарсан шингэн хаягдал, аюултай хог хаягдлыг дараах байдлаар зохистой хянаж, зохицуулна:

*Хог хаягдлын менежмент:*

Хог хаягдлын менежмент төлөвлөлт. Орон нутгийн зохицуулалтын шаардлагын дагуу хог хаягдлыг найрлага, эх үүсвэр, төрөл, үүсгэвэрийн хэмжээ зэргээс шалтгаалан ангилж ялгана. Хог



хаягдлаас үүсэх аюултай бодис, түүний тоо хэмжээг аль болох бага түвшинд барих эсвэл урьдчилан сэргийлэх зорилгоор хог боловсруулах ажлыг хэрэгжүүлнэ. Тухайлбал:

- Түүхий эд, орц зэргийг хор хөнөөл багатай материалаар орлуулах;
- Гэр ахуйн ажлын хамгийн сайн түршлагыг нэвтрүүлж хэрэгжүүлэх
- Шил, лааз зэрэг дахин ашиглаж болохуйц материалуудыг буцаан олгох ажлыг эрэлхийлэх зэрэг худалдан авалтын ажлыг нэвтрүүлэх;
- Аюулгүй болон аюултай хог хаягдал холилдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор хатуу хаягдлыг ялгах замаар аюултай хог хаягдлын үүсгэвэрийг багасгах.

Дахин боловсруулах төлөвлөгөө. Дахин боловсруулах төлөвлөгөө хэрэгжүүлэх замаар нийт хог хаягдлын хэмжээг үлэмж хэмжээгээр багасгах боломжтой. Тухайлбал, хог хаягдал боловсруулах үйлдвэрлэлийн үнэлгээ хийх, дахин боловсруулж болохуйц материалуудыг тодорхойлох байх боломжтой.

Цэвэрлэгээний ажлын журам. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллөөс зайлсхийхийн тулд гүйцэтгэгч нь барилгын хог хаягдлыг зохих ёсоор хадгалах, цэвэрлэх/устгах байгууламжийг засварлах зэрэг өдөр бүр талбайг цэвэрлэх журмыг тогтоож мөрдүүлнэ. Хэрэгжүүлэх арга нь хог хаягдлын шинж чанар, орон нутгийн дүрэм журамд нийцсэн байх ёстой бөгөөд дараах зарчмуудын нэг буюу хэд хэдэн зүйлийг агуулж болно:

- Талбай дээр болон ойр орчимд байгаа биологийн, химийн болон хатуу хог хаягдлыг аюулгүй болгож тусгайлан бэлтгэсэн зөвшөөрөгдсөн байгууламжид боловсруулна.
- Барилга байгууламж нурааснаас үүдэх хог хаягдлыг зохих ёсоор аль болох дахин ашиглана. Үлдсэн хог хаягдлыг орон нутгаас тогтоож зөвшөөрсөн газар руу зөөж хаяна.
- Гүйцэтгэгч нь ямар ч тохиолдолд хог хаягдлыг байгаль орны мэдрэмтгий газар хаяж болохгүй.
- Барилгын явцад үүссэн төмөр, ашигласан тос, илүүдэл материал зэрэг хог хаягдлыг дахин боловсруулах, тусгаарлах зөвшөөрөгдсөн газар хаяна.
- Ойролцоох газар дээр ямар нэгэн хог хаягдал, лаг хуримтлагдсан тохиолдолд эрх бүхий байгууллагуудын шаардлагын дагуу гүйцэтгэгч тал тухайн хог хаягдлыг нэн даруй зайлуулж, бохирлогдсон талбайг анхны байдалд нь оруулна.

Барилгын ажил болон нураан буулгах ажлын явцад хэрэглэж буй материалаас бага хэмжээний хорт бодис ялгаруулах боломжтой. Гүйцэтгэгч нь барилгын систем дэх аюултай материал, газрын тосны бүтээгдэхүүн (жишээлбэл, цахилгаан тоног төхөөрөмж, асбест агуулсан барилгын материал, чийдэн эсвэл чийдэнгийн тогтворжуулагч, ашигласан батерей, хоосон будагны сав гэх мэт) болон технологийн тоног төхөөрөмжид агуулагдах аюултай материал, газрын тосны бүтээгдэхүүн байгаа эсэхийг шалгаж, үнэлэх ёстой ба буулгах ажил эхлэхээс өмнө тэдгээрийг зайлуулж Дэлхийн Банкны Группийн ЭЭМ-ийн ерөнхий удирдамжийн ([www.ifc.org/ehsguidelines](http://www.ifc.org/ehsguidelines)) Аюултай материал ба аюултай хог хаягдлын менежментийн 1.5 ба 1.6-д заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

ҮДТ, Нөөц төвийн одоогийн агааржуулалтын системд электрон тоног төхөөрөмж суурилуулах, төхөөрөмжийг устгах, түүнчлэн шинээр худалдан авсан мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг ашиглалтын хугацаа нь дууссаны дараа устгах зэрэг нь электрон хог хаягдал (жишээ нь, никель-кадми батерей, компьютер болон бусад электрон тоног төхөөрөмжийн цахилгаан гүйдлийн хавтан, мөн нөөц батарей гэх мэт) үүсгэх магадлалтай. Нөөц генератор

болон үйлчилгээний тээврийн хэрэгслийн ашиглалтын үр дүнд хуучин дугуй, хаягдал тос, ашигласан шүүлтүүр гарч болно. Трансформаторын төхөөрөмж нь полихлоржуулсан бифенил (ПХБ), мөн хөргөх төхөөрөмж нь хөргөлтийн бодис (озон задлах боломжит бодис [ODS]) агуулж болзошгүй.

2015 онд Монгол Улсын Засгийн Газар 263 дугаар тогтоолын дагуу аюултай хог хаягдлын жагсаалтыг баталсан ба цахилгаан гүйдлийн хавтан, гидрохлорфтор нүүрстөрөгч, гидрофтор нүүрстөрөгч, асбест болон бусад хортой нэгдлүүдийг аюултай хог хаягдлын жагсаалтад багтсан байдаг.

Аюултай материалын менежментийн арга хэмжээний зөвлөмжүүд:

- Нөөц цахилгаан эрчим хүчний системд түлш нийлүүлэх, хадгалахад хамаарах түлш нийлүүлэх журам, асгарч шүүрэхээс урьдчилан сэргийлэх, хянах төлөвлөгөөг хэрэгжүүлэх, түлш хадгалах савыг хэтрүүлэн дүүргэхээс урьдчилан сэргийлэх, хоёрдогч битүүмж хийх;
- Лицензтэй байгууламжаар түр хадгалах, тээвэрлэх, эцсийн дахин боловсруулалт зэрэг хар тугалгын хүчлийн батерейг зохицуулах журмыг хэрэгжүүлэх;
- Шинэ туслах төхөөрөмж полихлоржуулсан бифенил (ПХБ) болон озон задлагч бодис (ОЗБ) агуулаагүй байх. Хуучин тоног төхөөрөмжийн ПХБ-ийг аюултай хог хаягдал болгон зохицуулах;
- Аюултай материалын агууламжийг үе шаттайгаар устгах олон улсын шаардлагыг хангасан электрон тоног төхөөрөмж худалдан авах.
- Материал асгарсан үед хариу арга хэмжээ авах журам (аюултай материал хадгалах байгууламжийг шингээгчээр хангах) боловсруулж, бүх асгарсан ялгарлыг нэн даруй цэвэрлэх.
- Аюултай материал нийлүүлэгчид (хэрэв бий бол) хаягдал гарсан тохиолдолд Монгол улсад зөвшөөрөлтэй байгууламжид, эсвэл тухайн бүс нутгийн өөр улсын тусгай зөвшөөрөлтэй байгууламж руу тээвэрлэх замаар зайлуулах, дахин боловсруулах үүрэгтэй. Аюултай хог хаягдлын бүх экспортыг БОАЖЯ-ны хяналт, зөвшөөрлийн дагуу хийх ёстой бөгөөд шаардлагатай бүх экспортын лицензийг авах ёстой.

Гүйцэтгэгч болон төслийн үр шимийг хүртэж буй дижитал дэд бүтцийн операторууд нь аюултай хог хаягдлыг аюулгүй хаягдлаас заавал тусгаарлах ёстой. Дээр дурдсан хог хаягдлын менежментийн аргуудыг ашигласан ч аюултай хаягдал үүсэхээс сэргийлж болохооргүй бол эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэхэд дараах зарчмын дагуу анхаарч ажиллана. Үүнд:

- Төсөл эхлэхээс дуусах хүртэл хугацаанд аюултай хог хаягдлын менежменттэй холбогдон гарч болох сөрөг нөлөө, эрсдлийн талаар ойлголттой байх
- Аюултай хаягдалтай харьцаж, түүнийг боловсруулж, зайлуулж байгаа гэрээт туслан гүйцэтгэгч нь зөвшөөрөл бүхий, нэр хүндтэй байгууллага мөн эсэх, олон улсын сайн туршлагыг дагаж мөрдөн ажиллаж байгаа эсэхийг сайтар нягтлах
- Холбогдох дотоод, гадаадын дүрэм журамтай нийцүүлэх

Хөрсний элэгдлийн хяналт:

Гүйцэтгэгч нь хөрсний элэгдлийг бууруулах буюу урьдчилан сэргийлэх нь:

- Их хэмжээний хур тунадасаас зайлсхийхийн тулд (жишээ нь, хуурай улиралд) боломжит практик хэмжээнд урьдчилан сэргийлэх хуваарь гаргах.

- Налуугийн урт ба эгц байдлыг багасгах, шугам зураг гаргах
- Газрын ил гарсан хэсгийг тогтворжуулахын тулд ургамлаар хучлага хийх
- Газар нутгийг яаралтай ургамалжуулах
- Барилгын дараах суваг, шуудууны зураг төсөл боловсруулах
- Эгц суваг ба налууг тэгшлэх (жишээ нь, сомронз хучлага ашиглах)

Засвар үйлчилгээ:

Засвар үйлчилгээ болон цаашдын цар хүрээг нэмэгдүүлэх үйл ажиллагаа нь аж ахуйн засвар үйлчилгээний сайн бодлогод нийцвэл зохих төдийгүй энэхүү БОАБЖ-д бэлтгэсэн бүх арга хэмжээ, удирдамжийг хэрэгжүүлнэ.

## **2.8 Газар шорооны ажил, хотгор, гүдгэр газрыг тэгшлэх**

Дижитал дэд бүтцийг шинэчлэх явцад гүйцэтгэгчид нь хамаарал бүхий газарт дараах шаардлагыг хэрэгжүүлнэ:

- Хөрсний цэвэрлэгээний талбайг багасгах.
- Нурангаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх замаар огтчисон гадаргуугийн налуугийн тогтвортой байдлыг хангана.
- Бүх түүхий эдийг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээс нийлүүлэн авна.
- Талбай дээрх хөрс арчлах зохистой аргууд:
  - Хөрсний цэвэрлэгээний талбайг багасгах.
  - Нурангаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх замаар гадаргууг хуулахдаа налуугийн тогтвортой байдлыг хангах.
  - Борооны усны урсацаас урьдчилан сэргийлэхийн тулд түр зуурын ус зайлуулах суваг эсвэл бусад зохих түр зуурын ус зайлуулах байгууламжийг ашиглах.
  - Хөрсний хаягдлыг (хэрэв бий бол) гэрээт этгээдээр устгуулах.

## **2.9 Барилгын ба тээврийн хэрэгслээс гарах хаягдал**

Гүйцэтгэгч нь бүх хог хаягдлыг гэрээт байгууллагад өгч, хог хаягдлыг зохицуулна. Гүйцэтгэгч нь орон нутгийн зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй байгуулсан хог хаягдлыг зайлуулах гэрээг байгаль орчны менежментийн хэрэгжилтийн тайланд хавсаргаж, ТХН-д хүргүүлнэ.

## **2.10 Барилгын ажлын үед баримтлах аюулгүй байдал**

Яаралтай тусламжийн журам: Гүйцэтгэгч нь эмнэлгийн/гал түймрийн онцгой байдал, түүнчлэн хүрээлэн буй орчны бохирдлын (их хэмжээний асгарсан түлш, ашигласан тос болон/эсвэл химийн хорт бодис гэх мэт) үед үр дүнтэй арга хэмжээ авах яаралтай тусламжийн горимуудыг боловсруулсан байх ёстой. Энэхүү журам нь яаралтай тусламжийн утасны дугаар болон зохих байгууллагад мэдэгдэх аргыг тусгасан байна. Гүйцэтгэгч компанийн үндсэн ажилтнуудын холбоо барих утасны дугаарыг мөн оруулсан байна.

Гал түймрээс урьдчилан сэргийлэх, хянах: Барилгын бүх талбай, холбогдох байр, халамжийн байгууламжууд гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохих төлөвлөгөө, удирдлагын

хяналттай байх ёстой. Талбайн түймрийн төлөвлөгөөг урьдчилан бэлтгэсэн байх ба засгийн газрын дүрэм журмыг зохих ёсоор хангасан байна. Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн ашиглалт, засвар үйлчилгээний явцад гүйцэтгэгч ажилчдад журам, түүнийг дагаж мөрдөх талаар сайтар тайлбарласан байх ёстой. Шатамхай бус материал, бүтээгдэхүүн, сав баглаа боодлын техникийн үзүүлэлтүүдийг боломжийн хэмжээнд дагаж мөрдөнө. Гүйцэтгэгч нь мөн тодорхой газруудад тохирсон засгийн газрын шаардлагыг мөрдөнө.

Тоног төхөөрөмжийн ашиглалт: Гүйцэтгэгч нь ойр орчмын оршин суугчид болон тэдэнд аюулгүй байдлын эрсдэл болон/эсвэл хүндрэл учруулахгүй байлгах үүднээс төхөөрөмжийг зөв ажиллуулах бүх боломжит урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна. Кран болон бусад том тоног төхөөрөмжийн ажиллагааг сайтар хянах ба үүнд зөвшөөрөл шаардлагатай байх магадлалтай.

Ослоос урьдчилан сэргийлэх. Үүргийнхээ дагуу гүйцэтгэгч барилгын орчимд байх хүмүүс болон эд хөрөнгийг барилгын ослоос хамгаалсан байх ёстой. Гүйцэтгэгч нь засгийн газрын аюулгүй байдлын бүх шаардлагыг дагаж мөрдөх, ослоос зайлсхийхэд шаардлагатай бусад арга хэмжээг хариуцах ба үүнд дараахь зүйлс багтана.

- Барилгын талбайд анхааруулах тэмдэг/самбарыг зохих ёсоор суурилуулах;
- Сүргүүлийн сурагчид барилгын талбайн ойролцоо байх тохиолдолд замын хөдөлгөөний аюулгүй байдлын ажилтнуудыг хичээлийн цагаар хөдөлгөөнд оролцуулах;
- Ажил эхлэхийн өмнө барилгын ажилчдад аюулгүй ажиллагааны сургалт явуулах;
- Барилгын ажилчдыг шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл, хувцасаар (нүдний шил, бээлий, амьсгалын аппарат, тоосны маск, хатуу малгай, ган хуруутай, бариултай гутал гэх мэт) хангах, тэдгээрийн хэрэглээг мөрдүүлэх;
- Асбест агуулсан материал болон бусад хорт бодисыг зайлуулах ажлыг тусгайлан бэлтгэгдсэн ажилчид хийж, устгах;
- Ямар ч төрлийн онцгой байдлын үед бүх ажлыг түр хугацаагаар зогсооно.

